



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2025 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 228

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Засгийн газрын авто бааз” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 198,000,000.00 (нэг зуун ерэн найман сая) төгрөгийн балансын үнэ, 133,650,000.00 (нэг зуун гучин гурван сая зургаан зуун тавин мянга) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Эрдэнэс критикал минералс” төрийн өмчит үйлдвэрийн газарт балансаас шилжүүлсүгэй.

2.“Засгийн газрын авто бааз” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Г.Чинзориг, “Эрдэнэс критикал минералс” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Д.Тогтохсүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим системд”-д бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 134 дүгээр тогтоолыг хүчингүй болсон тооцсугай.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132880792
10-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлогогозохицуулалтын газрын
2026 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн
22 дугаар толгооолын хавсралт

"ЗАСГИЙН ГАЗРЫН АВТОБААЗ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, "ЭРДЭНЭС КРИТИКАЛ МИНЕРАЛС" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ
БАЛАНСАAS БАЛАНСАД ШИЛЖУУЛЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон огноо	Балансын үнэ (төгрөг)	Хуриимтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Ниссан Патрол, 02-99 УБ3, JT1TANU62Z0100252	2018/2018	198,000,000.00	133,650,000.00	64,350,000.00
	НИЙТ ДҮН		198,000,000.00 (нэг зуун ерэн найман сая)	133,650,000.00 (нэг зуун гучин гурван сая зургаан зуун тавин мянга)	64,350,000.00 (жаран дөрвөн сая гурван зуун тавин мянга)